ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Биеийн тамир, спортын улсын хорооны 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2024/16/НА-СТА-ТТЗ**



| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Улаанбаатар хот<br><br>2023 он | Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Энхдалай<br>Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn<br>Ахлах аудитор: А.Даваадорж<br>Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn<br>Аудитор: М.Ганбаатар<br>Утас: 261628 Цахим хаяг: ganbaatarm@audit.gov.mn<br>Аудитор: Я.Марал-Эрдэнэ<br>Утас: 261628 Цахим хаяг: maral-erdeneya@audit.gov.mn |



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/828

танай ____________-ны № ______________-т

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
УЛСЫН ХОРООНЫ ДАРГА
О.БАТТУЛГА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Биеийн тамир, спортын улсын хорооны 2023 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн төсвийг зохистой удирдаагүй авлага, өр төлбөр үүсгэсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй, олон жилийн насжилттай авлагыг барагдуулаагүй, төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтэрсэн бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авсан, хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийг хянаагүй, хугацаанд нь хүлээн аваагүй, гэрээний үүргийг биелэлтийг хангуулаагүй зэрэг 35,081.9 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байх", "Толилуулга ба тодруулга", "Эрх ба үүрэг, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн 2022 оны 8 дугаар сарын 29-ний өөрчлөлтөөр Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүнд Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргатай, эрхлэх асуудлын хүрээнд Биеийн тамир, спортын улсын хороог төсвийн төвлөрүүлэн захирагч байхаар тусгасан.

Биеийн тамир, спортын улсын хороо нь хөгжлийн чиг хандлага, хүн амын хэрэгцээнд нийцүүлэн биеийн тамир, спортын салбарын бодлогын үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар бие бялдрын боловсролтой, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг иргэнийг төлөвшүүлэх чиглэлээр 2 газар 6 хэлтэстэй, 21 аймаг, 9 дүүргийн Биеийн тамир спортын хороо, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Спортын анагаах ухааны эрдэм шинжилгээний төв зэрэг нийт 35 нэгжтэйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

## Аудитын гол асуудал

Монгол Улс анх удаа олон улсын спортын наадам "Улаанбаатар 2023" Зүүн Азийн залуучуудын наадмыг зохион байгуулж, долоон улсын олимпын хорооны 870 гаруй тамирчин 11 спортын 12 төрлөөр өрсөлдсөн байна. Тус наадамд Биеийн тамир, спортын улсын хорооноос Засгийн газрын 2017 оны “Зүүн азийн залуучуудын II наадам зохион байгуулах тухай” 268 дугаар тогтоолын дагуу 10,000.0 сая төгрөгийн санхүүжилт гаргасан байна.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Цаг гаргая” биеийн тамирын арга хэмжээ, "Эрүүл Монгол хүн" үндэсний фестиваль, Монголын хүүхдийн спортын зуны VII их наадам, "Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг амжилттай зохион байгуулж, төсвөөс 4,600.0 сая төгрөг зарцуулсан байна.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* *\/мянган төгрөгөөр/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **137,696,967.0** | **187,311,104.1** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 5,909,551.0 | 5,182,045.6 |
| 33 | АВЛАГА | 1,787,330.3 | 1,866,659.1 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 3,792,511.6 | 4,082,080.5 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 2,769,770.4 | 3,924,220.0 |
| **360** | **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | **123,437,803.6** | **17,225,609.0** |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **172,203,454.8** | **144,546,871.5** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **172,203,454.8** | **144,546,871.5** |
| 39200 | Биет хөрөнгө | 157,945,350.0 | 131,324,143.6 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 14,143,288.8 | 13,222,727.9 |
| 39400 | Бусад хөрөнгө /ТӨҮГ/ | 114,816.0 | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **309,900,421.7** | **331,857,975.7** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **6,929,861.0** | **5,344,991.7** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 6,929,861.0 | 5,344,991.7 |
| 41300 | Өглөг | 6,902,483.9 | 5,344,991.7 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 27,377.1 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **302,970,560.8** | **326,512,984.0** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 302,970,560.8 | 326,512,984.0 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 53,863,018.9 | 53,863,018.9 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 31,919,868.7 | - |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 21,943,150.1 | - |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 31,429,060.6 | - |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 825,714.2 | - |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 170,196,283.8 | 252,505,687.6 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 46,656,483.3 | 20,144,277.5 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **309,900,421.7** | **331,857,975.7** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* *\/мянган төгрөгөөр/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **204,507,231.5** | **265,777,268.4** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 138,683,899.8 | 151,118,775.8 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 138,683,899.8 | 151,118,775.8 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 65,823,331.8 | 114,658,492.6 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 45,785,009.0 | 82,503,519.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 45,785,009.0 | 82,503,519.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 42,770,266.0 | 72,197,982.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 9,251,891.1 | 15,031,957.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,149,971.0 | 1,849,008.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 6,399,520.2 | 8,445,971.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 985,536.1 | 929,262.9 |
| 2105 | Нормативт зардал | 579,896.0 | 250,932.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 660,144.1 | 1,155,245.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 55,091.2 | 129,715.1 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,196,708.2 | 18,145,228.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,491,508.1 | 26,260,661.4 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,014,742.9 | 10,305,536.9 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **157,722,222.5** | **183,273,749.1** |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 17.6 | 0.0 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 103,895.0 | 3,028,103.8 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **157,618,345.0** | **180,245,645.3** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* */мянган төгрөгөөр/*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **69,256,610.10** | **125,833,524.20** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,575,456.40** | **9,634,845.90** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **3,575,456.40** | **9,634,845.90** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **65,681,153.70** | **116,198,678.20** |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **48,570,343.30** | **86,026,779.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **48,570,343.30** | **86,026,779.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **43,045,003.30** | **75,563,715.30** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 9,417,107.30 | 15,042,020.90 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,152,097.20 | 1,854,910.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 6,478,214.60 | 8,344,789.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 526,903.80 | 529,032.30 |
| 2105 | Нормативт зардал | 518,594.80 | 144,764.20 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 788,725.90 | 2,101,611.20 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 55,207.20 | 131,434.80 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,381,564.60 | 19,833,548.80 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,726,587.90 | 27,581,604.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,525,340.00 | 10,463,064.50 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **20,686,266.80** | **39,806,744.40** |
| **IV** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | **3,931.80** | **-** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **23,310,033.60** | **34,624,698.80** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 23,310,033.60 | 34,624,698.80 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 23,310,033.60 | 34,624,698.80 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(23,306,101.80)** | **(34,624,698.80)** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **41,464.20** | **-** |
| 14 | Бусад эх үүсвэр | 144,604.20 | - |
| 25 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 103,140.00 | - |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **(2,578,370.80)** | **5,182,045.60** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 8,487,921.80 | - |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 5,909,551.00 | 5,182,045.60 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* *|мянган төгрөгөөр|*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **143,067,358.20** | **143,067,358.20** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 1313878.4 | 1313878.4 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 144,381,236.70 | 144,381,236.70 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 1,104,920.00 | 1,104,920.00 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 157,618,345.00 | 157,618,345.00 |
| **10** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **302,970,560.80** | **302,970,560.80** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 146,026,072.80 | 146,026,072.80 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 146,026,072.80 | 146,026,072.80 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 241,265.80 | 241,265.80 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 180,245,645.30 | 180,245,645.30 |
| **20** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **326,512,983.90** | **326,512,983.90** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 111,870,636,100.00 | 108,819,190,473.06 | 3,051,445,626.94 | 97.3 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 63,047,470,500.00 | 60,000,895,145.06 | 3,046,575,354.94 | 95.2 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 57,650,461,100.00 | 54,870,611,305.73 | 2,779,849,794.27 | 95.2 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 15,025,692,000.00 | 14,031,572,800.10 | 994,119,199.90 | 93.4 |
| 210101 | Үндсэн цалин | 8,982,252,600.00 | 8,503,146,365.21 | 479,106,234.79 | 94.7 |
| 210102 | Нэмэгдэл | 3,156,874,600.00 | 2,521,853,230.27 | 635,021,369.73 | 79.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,868,833,400.00 | 1,528,476,882.64 | 340,356,517.36 | 81.8 |
| 210104 | Урамшуулал | 1,017,731,400.00 | 1,393,781,996.83 | (376,050,596.83) | 136.9 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 84,314,325.15 | (84,314,325.15) | 0.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,938,342,500.00 | 1,745,185,167.60 | 193,157,332.40 | 90.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,301,553,100.00 | 1,199,618,623.22 | 101,934,476.78 | 92.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 155,167,200.00 | 141,315,866.15 | 13,851,333.85 | 91.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 136,323,900.00 | 111,640,537.41 | 24,683,362.59 | 81.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 35,163,400.00 | 26,955,495.52 | 8,207,904.48 | 76.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 310,134,900.00 | 265,654,645.30 | 44,480,254.70 | 85.7 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 230,531,400.00 | 219,042,137.58 | 11,489,262.42 | 95.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 106,230,800.00 | 96,419,014.47 | 9,811,785.53 | 90.8 |
| 210302 | Түлш, халаалт | 87,416,400.00 | 86,229,589.00 | 1,186,811.00 | 98.6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 36,884,200.00 | 36,393,534.11 | 490,665.89 | 98.7 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 374,126,800.00 | 361,821,708.98 | 12,305,091.02 | 96.7 |
| 210401 | Бичиг хэрэг | 48,289,100.00 | 50,065,600.00 | (1,776,500.00) | 103.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 75,018,600.00 | 71,776,969.00 | 3,241,631.00 | 95.7 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 63,016,000.00 | 60,548,203.70 | 2,467,796.30 | 96.1 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 23,700,900.00 | 18,996,196.00 | 4,704,704.00 | 80.1 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 164,102,200.00 | 160,434,740.28 | 3,667,459.72 | 97.8 |
| **2105** | **Нормативт зардал** | 505,500,000.00 | 126,369,184.50 | 379,130,815.50 | 25.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 500,000,000.00 | 120,869,184.50 | 379,130,815.50 | 24.2 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,500,000.00 | 5,500,000.00 | - | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,180,476,200.00 | 2,879,672,844.28 | 300,803,355.72 | 90.5 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,559,169,200.00 | 1,541,803,962.00 | 17,365,238.00 | 98.9 |
| 210602 | Тавилга | 640,000,000.00 | 631,969,975.00 | 8,030,025.00 | 98.7 |
| 210604 | Урсгал засвар | 981,307,000.00 | 705,898,907.28 | 275,408,092.72 | 71.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 74,701,500.00 | 66,275,153.00 | 8,426,347.00 | 88.7 |
| 210702 | Дотоод албан томилолт | 74,701,500.00 | 66,275,153.00 | 8,426,347.00 | 88.7 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 20,494,567,700.00 | 19,713,148,643.94 | 781,419,056.06 | 96.2 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,383,672,700.00 | 19,625,848,270.94 | 757,824,429.06 | 96.3 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 16,196,000.00 | 9,186,000.00 | 7,010,000.00 | 56.7 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 10,147,500.00 | 8,499,770.00 | 1,647,730.00 | 83.8 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 5,046,100.00 | 2,597,751.00 | 2,448,349.00 | 51.5 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 1,909,200.00 | 984,800.00 | 924,400.00 | 51.6 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 25,401,000.00 | 23,149,230.00 | 2,251,770.00 | 91.1 |
| 210807 | Газрын төлбөр | 52,195,200.00 | 42,882,822.00 | 9,312,378.00 | 82.2 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | | - | 0.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15,826,523,000.00 | 15,727,523,665.75 | 98,999,334.25 | 99.4 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,811,007,700.00 | 15,719,172,615.75 | 91,835,084.25 | 99.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,515,300.00 | 8,351,050.00 | 7,164,250.00 | 53.8 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,397,009,400.00 | 5,130,283,839.33 | 266,725,560.67 | 95.1 |
| **2131** | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 115,045,000.00 | 106,813,021.00 | 8,231,979.00 | 92.8 |
| **213102** | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 115,045,000.00 | 106,813,021.00 | 8,231,979.00 | 92.8 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,281,964,400.00 | 5,023,470,818.33 | 258,493,581.67 | 95.1 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 4,630,000,000.00 | 4,420,690,000.00 | 209,310,000.00 | 95.5 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 536,428,300.00 | 493,803,564.33 | 42,624,735.67 | 92.1 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 115,536,100.00 | 108,977,254.00 | 6,558,846.00 | 94.3 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 48,823,165,600.00 | 48,818,295,328.00 | 4,870,272.00 | 100.0 |
| 220001 | Барилга байгууламж | 48,823,165,600.00 | 48,818,295,328.00 | 4,870,272.00 | 100.0 |
| 222001 | Тоног төхөөрөмж | | | - | 0.0 |
| 223001 | Бусад хөрөнгө | | | - | 0.0 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 111,870,636,100.00 | 108,818,462,967.66 | 3,052,173,132,34 | 97.3 |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 111,870,636,100.00 | 108,747,733,068.86 | 3,122,903,031.14 | 97.2 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 111,870,636,100.00 | 108,747,733,068.86 | 3,122,903,031.14 | 97.2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | | 70,729,898.80 | (70,729,898.80) | |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 70,729,898.80 | (70,729,898.80) | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 5,909,551.00 | (5,909,551.00) | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 5,182,045.60 | (5,182,045.60) | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 35 | 35 | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 35 | 35 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 770 | 770 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 47 | 47 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 459 | 459 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 264 | 264 | - | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* *\/ төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **11,590,502,099.18** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **11,590,502,099.18** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **9,440,038,709.73** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **704,150,850.81** |
| 210101 | Үндсэн цалин | | 514,502,357.73 |
| **2102** | **Нэмэгдэл** | | **76,315,773.08** |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 1,862,500.00 |
| **210104** | **Урамшуулал** | | **15,300,720.00** |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 96,169,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **79,748,943.69** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 56,702,270.92 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 6,039,503.34 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 4,926,908.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 1,047,058.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 11,033,202.28 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **91,757,669.95** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 14,759,953.95 |
| 210302 | Түлш, халаалт | | 76,774,966.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 222,750.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **162,290,331.00** |
| 210401 | Бичиг хэрэг | | 1,842,560.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 25,242,570.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 1,752,740.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 6,000,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 615,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 126,837,461.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | **18,395,000.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 900,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 17,495,000.00 |
| **2103** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **457,774,830.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 256,009,100.00 |
| 210602 | Тавилга | | 57,977,900.00 |
| 210604 | Урсгал засвар | | 143,787,830.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **65,159,600.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | | 2,608,400.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | 62,551,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **256,439,133.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 256,140,825.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 284,600.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 13,708.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **7,604,322,351.28** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 7,604,322,351.28 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **2,150,463,389.45** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 2,055,089,556.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | 15,526,153.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | 1,449,500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 590,063,403.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **95,373,833.45** |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжилтээс төвлөрүүлэх шилжүүлэг | | 95,373,833.45 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **11,590,502,099.18** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **11,590,502,099.18** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 39,000,000.00 |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | | 18,190,453.10 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 6,695,880,578.96 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 3,866,145,272.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 971,285,795.12 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 35 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 20 байгууллагад дүгнэлт гаргаж, 15 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” 18 дүгнэлт, Өмнөговь аймгийн Биеийн тамир, спортын газар болон Биеийн тамир, спортын улсын хороонд **“Хязгаарлалттай”** дүгнэлт өгсөн.

### 3.1 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар Биеийн тамир, спортын улсын хороо Спортыг дэмжих сан, Биеийн тамир спортын салбарын Хөрөнгө оруулалт, их засвар, Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийг түүвэрт хамруулан шалгасан.

Аудитаар нийт 13,239.5 сая төгрөгийн 2 зөрчил илэрснээс 1,172.6 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 12,066.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

#### 3.1.1 Төлбөрийн акт

1. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-д батлагдсан төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт, мөн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-д батлагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч байгууллага нь цаашид хэрэгжүүлэх боломжгүй болж бүрэн зогссон зэрэг нийт 1,172.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй, барьцаа хөрөнгийн дансанд байршиж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "*Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ: 45.2.2. төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл*" гэж заасантай нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>: Барьцаа хөрөнгийн дансанд байршиж байгаа хэрэгжээгүй хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтийг улсын төсөвт татан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.*

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 6,571.5 сая төгрөгийн 20 алдааг санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан.

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Дорнод аймгийн БТСГ | 1 | 5,100.0 | - | - | 1 | 5,100.0 | 1 | 5,100.0 | | | | |
| Булган аймгийн БТСГ | 1 | - | - | - | 1 | - | 1 | - | | | | |
| Говь-Алтай аймгийн БТСГ | 3 | 80,477.6 | - | - | 3 | 80,477.6 | 3 | 80,477.6 | | | | |
| Өмнөговь аймгийн БТСГ | 5 | 4,167,116.7 | - | - | 5 | 4,167,116.7 | 5 | 4,167,116.7 | | | | |
| Ховд аймгийн БТСГ | 1 | 4,000.0 | - | - | 1 | 4,000.0 | 1 | 4,000.0 | | | | |
| Төв аймгийн БТСГ | 2 | 53,024.8 | - | - | 2 | 53,024.8 | 2 | 53,024.8 | | | | |
| Биеийн тамир, спортын улсын хороо /аппарат/ | 1 | 2,038,821.0 | 1 | 2,038,821.0 | - | - | 1 | 2,038,821.0 | | | | |
| Багахангай дүүргийн БТСХ | 3 | 74,077.4 | 2 | 70,155.9 | 1 | 3,921.5 | 3 | 74,077.4 | | | | |
| Сонгинохайрхан дүүргийн БТСХ | 3 | 148,868.4 | - | - | 3 | 148,868.4 | 3 | 148,868.4 | | | | |
| **Дүн** | **20** | **6,571,485.8** | **3** | **2,108,976.9** | **17** | **4,462,509.0** | **20** | **6,571,485.8** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 29,744.3 сая төгрөгийн 73 зөрчил илэрснээс 1,219.2 сая төгрөгийн 12 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13,016.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 22 албан шаардлага хүргүүлж, 15,508.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 39 зөвлөмжийг хүргүүлсэн байна

/мянган төгрөгөөр/

| д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Биеийн тамир, спортын улсын хороо ТТЗ | 2 | 13,239,464.5 | 1 | 1,172,564.5 | | | 1 | 12,066,900.0 | | | | |
| | **ТТЗ** | **2** | **13,239,464.5** | **1** | **1,172,564.5** | | | **1** | **12,066,900.0** | | | | |
| 1 | Архангай аймгийн БТСГ | 1 | 16,650.0 | - | - | 1 | 16,650.0 | - | - | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Багахангай дүүргийн БТСХ | 3 | 5,941.1 | - | - | - | - | 3 | 5,941.1 | | | | |
| 3 | Баянзүрх дүүргийн БТСХ | 3 | 55,889.4 | - | - | - | - | 3 | 55,889.4 | | | | |
| 4 | Баянхонгор аймгийн БТСГ | 4 | 8,743,480.1 | 1 | 300.0 | 3 | 8,743,180.1 | - | - | | | | |
| 6 | Булган аймгийн БТСГ | 2 | 696.7 | 1 | 50.3 | - | - | 1 | 646.4 | | | | |
| 7 | Говь-Алтай аймгийн БТСГ | 1 | 15,190.3 | - | - | 1 | 15,190.3 | - | - | | | | |
| 8 | Говьсүмбэр аймгийн БТСГ | 2 | 1,592.0 | 1 | 1,592.0 | - | - | 1 | - | | | | |
| 9 | Дархан-Уул аймгийн БТСГ | 2 | 13,750.5 | - | - | 1 | 12,000.0 | 1 | 1,750.5 | | | | |
| 10 | Дорноговь аймгийн БТСГ | 3 | 206,112.7 | 1 | 53.1 | 1 | - | 1 | 206,059.6 | | | | |
| 11 | Дорнод аймгийн БТСГ | 2 | 40,000.0 | - | - | 1 | 40,000.0 | 1 | - | | | | |
| 12 | Дундговь аймгийн БТСГ | 4 | 29,746.2 | 2 | 987.7 | 1 | 2,513.9 | 1 | 26,244.6 | | | | |
| 13 | Завхан аймгийн БТСГ | 4 | 239,595.5 | - | - | - | - | 4 | 239,595.5 | | | | |
| 14 | Нийслэлийн БТСГ | 1 | 56,590.8 | - | - | - | - | 1 | 56,590.8 | | | | |
| 15 | Орхон аймгийн БТСГ | 4 | 27,598.8 | 1 | 3,012.0 | 2 | 24,586.8 | 1 | - | | | | |
| 16 | Өмнөговь аймгийн БТСГ | 8 | 125,154.2 | 2 | 22,831.2 | 3 | 47,056.0 | 3 | 55,267.0 | | | | |
| 18 | Сүхбаатар аймгийн БТСГ | 1 | 8,192.0 | - | - | - | - | 1 | 8,192.0 | | | | |
| 19 | Сэлэнгэ аймгийн БТСГ | 2 | 1,654.6 | - | - | 1 | 1,654.6 | 1 | - | | | | |
| 20 | Төв аймгийн БТСГ | 1 | 1,975.0 | - | - | - | - | 1 | 1,975.0 | | | | |
| 21 | Хан-Уул дүүргийн БТСХ | 2 | 20,026.0 | - | - | - | - | 2 | 20,026.0 | | | | |
| 22 | Ховд аймгийн БТСГ | 1 | 4,000.0 | - | - | - | - | 1 | 4,000.0 | | | | |
| 23 | Хөвсгөл аймгийн БТСГ | 3 | 280.0 | 1 | 280.0 | - | - | 2 | - | | | | |
| 24 | Хэнтий аймгийн БТСГ | 1 | 4,500.0 | - | - | 1 | 4,500.0 | - | - | | | | |
| 25 | Чингэлтэй дүүргийн БТСХ | 3 | 35,144.5 | - | - | - | - | 3 | 35,144.5 | | | | |
| 26 | Биеийн тамир, спортын улсын хороо /аппарат/ | 13 | 6,851,095.0 | 1 | 17,500.0 | 6 | 4,109,293.9 | 6 | 2,724,301.1 | | | | |
| **Дүн** | | **71** | **16,504,855.4** | **11** | **46,606.3** | **22** | **13,016,625.6** | **38** | **3,441,623.5** | | | | |
| **Нийт дүн** | | **73** | **29,744,319.9** | **12** | **1,219,170.8** | **22** | **13,016,625.6** | **39** | **15,508,523.5** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Биеийн тамир, спортын хорооны харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар нийт 2,280.3 сая төгрөгийн 35 зөрчил илэрснээс 1.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,744.1 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага хүргүүлж, 534.6 сая төгрөгийн зөрчилд 21 зөвлөмж өгсөн.

/мянган төгрөгөөр/

| Д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Биеийн тамир, спортын улсын хороо ТТЗ | 3 | - | | | | | 3 | - | | | | |
| | **ТТЗ дүн** | **3** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **3** | **-** | | | | |
| 1 | Архангай аймгийн БТСГ | 1 | - | - | - | 1 | - | - | - | | | | |
| 2 | Баянгол дүүргийн БТСХ | 1 | 25,383.0 | - | - | - | - | 1 | 25,383.0 | | | | |
| 3 | Баянзүрх дүүргийн БТСХ | 1 | 43,695.7 | - | - | - | - | 1 | 43,695.7 | | | | |
| 4 | Говьсүмбэр аймгийн БТСГ | 2 | 54,023.3 | 1 | 1,592.0 | 1 | 52,431.3 | - | - | | | | |
| 5 | Дархан-Уул аймгийн БТСГ | 1 | 88,887.7 | - | - | - | - | 1 | 88,887.7 | | | | |
| 6 | Дорноговь аймгийн БТСГ | 1 | - | - | - | - | - | 1 | - | | | | |
| 7 | Дундговь аймгийн БТСГ | 1 | 19,825.7 | - | - | 1 | 19,825.7 | - | - | | | | |
| 8 | Налайх дүүргийн БТСХ | 1 | 8,300.0 | - | - | - | - | 1 | 8,300.0 | | | | |
| 9 | Нийслэлийн БТСГ | 3 | 270,818.7 | - | - | - | - | 3 | 270,818.7 | | | | |
| 10 | Өвөрхангай аймгийн БТСГ | 1 | 19,887.4 | - | - | 1 | 19,887.4 | - | - | | | | |
| 11 | Өмнөговь аймгийн БТСГ | 1 | 162,032.6 | - | - | 1 | 162,032.6 | - | - | | | | |
| 12 | Сүхбаатар аймгийн БТСГ | 1 | 20,000.0 | - | - | - | - | 1 | 20,000.0 | | | | |
| 13 | Сэлэнгэ аймгийн БТСГ | 1 | 54,099.9 | - | - | - | - | 1 | 54,099.9 | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | Хөвсгөл аймгийн БТСГ | 2 | 60,000.0 | - | - | 1 | 60,000.0 | 1 | - | | | | |
| 15 | Чингэлтэй дүүргийн БТСХ | 1 | 23,392.0 | - | - | - | - | 1 | 23,392.0 | | | | |
| 16 | Биеийн тамир, спортын улсын хороо /аппарат/ | 8 | 500,000.0 | - | - | 5 | 500,000.0 | 3 | - | | | | |
| 17 | Спортыг дэмжих сан | 2 | - | - | - | 2 | - | - | - | | | | |
| 18 | Спортын анагаах ухааны эрдэм шинжилгээний төв | 3 | - | - | - | - | - | 3 | - | | | | |
| **Дүн** | | **32** | **1,350,346.0** | **1** | **1,592.00** | **13** | **814,177.0** | **18** | **534,577.0** | | | | |
| **Нийт дүн** | | 35 | 1,350,346.0 | 1 | 1,592.00 | 13 | 814,177.0 | 21 | 534,577.0 | | | | |